

## АНГЛИ ХЭЛНИЙ ОЙРОЛЦОО УТГАТ ҮГСИЙН ХЭРЭГЛЭЭ, ОРЧУУЛГЫН СУДАЛГАА

(Эдийн засгийн салбар дах үйл үгсийн жишээн дээр)

Цэвээнсүрэнгийн Төмөрбарс<sup>1, a \*</sup>, Лувсанцэрэнгийн Болортамир<sup>2, b</sup>

<sup>1</sup>Санхүү Эдийн Засгийн Их Сургууль

<sup>2</sup>Санхүү Эдийн Засгийн Их Сургууль

<sup>a</sup>tumurbars.ts@ufe.edu.mn, <sup>b</sup>bolortamir.l@ufe.edu.mn

### Хураангуй

*Аливаа хэлний үгийн санд ойролцоо утгат үгс чухал байр суурь эзэлдэг. Ойролцоо утгат үгсийн ялгааг танин мэдэж, түүнийг найруулгад зөв хэрэглэснээр өөрийн санаа бодлоо уран яруу илэрхийлэх, нэг хэлбэрийг ойрхон давтахаас зайлсхийх, нэг санааг өөр өөр хэлбэрээр илэрхийлэх боломжтой байдаг тул энэ нь хэл шинжлэлд гарцаагүй ач холбогдолтой байдаг. Уг сэдвийг сонгон авч судалснаар эдийн засгийн салбар дах ойролцоо утгат үйл үгсийн хэрэглээ, илэрхийлэх утгын нарийн ялгааг тодруулж, тэдгээрийг өгүүлбэрт зөв хэрэглэж сурах улмаар тэндээс олж мэдсэн зүйлсээ өөрийн мэдлэг болгон хувиргахыг гол зорилго болголоо. Энэхүү судалгааны ажилд түүвэр судалгааны арга, задлан шинжлэх болон нэгтгэн дүгнэх зэрэг судалгааны аргуудыг хэрэглэсэн бөгөөд эдийн засгийн салбарын ойролцоо утгатай үйл үгс нь хам сэдвээсээ шалтгаалж өөр хоорондоо нэг нэгнээ орлож хэрэглэгдэх байдал нь дутмаг болохыг судалгааны үр дүн харууллаа.*

**Түлхүүр үг:** ойролцоо утга, орлох үйл үг, үл орлох үйл үг, ойролцоо үйл үг

## ОРШИЛ

Аливаа хэлний үгийн санд ойролцоо утгат үгс чухал байр суурь эзэлдэг. Ойролцоо утгат үгсийн ялгааг танин мэдэж, түүнийг найруулгад зөв хэрэглэснээр өөрийн санаа бодлоо уран яруу илэрхийлэх, нэг хэлбэрийг ойрхон давтахаас зайлсхийх, нэг санааг өөр өөр хэлбэрээр илэрхийлэх боломжтой байдаг тул энэ нь хэл шинжлэлд гарцаагүй ач холбогдолтой байдаг. Уг сэдвийг сонгон авч судалснаар эдийн засгийн салбар дах ойролцоо утгат үйл үгсийн хэрэглээ, илэрхийлэх утгын нарийн ялгааг тодруулж, тэдгээрийг өгүүлбэрт зөв оновчтой сонгон хэрэглэхэд бага ч болов хувь нэмэр оруулахыг зорьлоо.

Аливаа хэлний баялаг гэдэг бол зөвхөн үгсийн сан дахь үгсийн олон цөөнийг хэлдэггүй, утга санаа, түүний өнгө аясыг ялган зааглах, илэрхийлэн гаргах боломжийн тухай асуудал байдаг. Хэл хөгжихөд нэг ухагдахуун утга санааг зүйл бүрээр илэрхийлэх арга боловсрохын зэрэгцээ үгсийн санд утга ижил, ойролцоо утгат үгс бий болдог. Аль ч хэлний үгийн санд ойролцоо утгат үг буюу синоним нэн чухал байр эзэлдэг (*Бямбасан, 1982. х.45*).

Ойролцоо утгат үгс гэдэг нь нэг нэртэй гэсэн утга бүхий эртний Грек Syn (“with”) – *опота* (“name”) хэмээх үгнээс гаралтай. Синоним гэдэг нь яг адилгүй боловч ойролцоо утга илэрхийлэх хэлний арга хэрэглүүрүүд юм (*Базаррагчаа, 2005*). Англи хэлэнд дуудлага өөр боловч утга ойролцоо үгсийг **synonyms**, синонимийг бүрдүүлж байгаа үгсийг **synonymous** гэх бөгөөд харин синоним болж байгаа байдлыг нь **synonymy** гэнэ. Синонимын тухай ердийн тодорхойлолт нь дуудлага өөр боловч утга ойролцоо буюу адил үгсийг хэлнэ гэх бөгөөд үүнийг зарим эрдэмтэд яг таг зөв тодорхойлолт биш гэж үздэг. Тухайлбал Профессор А.А.Реформатский зэрэг хүмүүсийн саналаар үнэндээ синонимын утга ухагдахуун нь ойролцоо буюу адил биш, харин нэрлэж байгаа юм нь адил, ойролцоо байдаг гэж үзэж байна. Жишээ нь нүд-мэлмий, гар-мутар зэрэг үгс нь синоним болох бөгөөд үүнд нэрлэж байгаа юм ба ухагдахуун нь ижил байна. Ойролцоо нэрийн нэгийг нөгөөгөөр нь сольж хэрэглэхэд зарим тохиолдолд болох боловч ихэнхдээ найруулгын талаар буюу мөн хэрэглэж хэвшсэн байдлын хувьд өөр өөр тул сольж хэрэглэж болохгүй тохиолдол олон бий. **Алс, хол** хоёр бол ойролцоо нэр юм. Алс газар-хол газар, алс нутаг-хол нутаг, алсаас ирэх-холоос ирэх гэх зэргээр нэгийг нөгөөгөөр сольж болох боловч энэ мэтээр хэрэглэж болохгүй газар байна. Жишээлбэл: холын хамаатан, холын төрөл, “ус цасны ойр нь, ураг төрлийн хол нь дээр” гэхэд зөвхөн хол гэдэг үгийг хэрэглэхээс биш түүнийг алс гэдэг үгээр сольж болохгүй (*Отгонсүрэн, 1998, х.31*).

Ойролцоо эквивалентээр (синоним) орчуулах арга байдаг.

Жишээлбэл: to sleep- унтах. Монгол хэл дээр олон утга байдаг. Давсанд явах, нүдний хор гаргах г.м.

Эх хэлнээс орчуулга хийхдээ тухайн сэдэвт ойролцоо утга санаа агуулж байгаа үгийг хэрэглэнэ. Үг болгоны санаа өөр өөр байдаг.

Бүрдэх хэсгүүдийн анализ: тухайн ойролцоо утга бүхий үгнүүдээс аль нэг дүйцэн байгаа үгийг сонгох.

Хонгор сум хорджээ.

Хордох – To be toxicaled (ерөнхий)

To be poisoned  
To be contaminated  
To be murdered  
To be gemmed down (“Translation theory”, 2015)

## 1. СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, АРГАЗҮЙ

Судалгааны ажлын зорилгодоо хүрэхийн тулд үндсэн хэрэглэгдэхүүн болгон СЭЗИС-ийн Эдийн засгийн англи хэлний хичээлийн үндсэн сурах бичиг ‘English for Economics’-ийг сонгон авч, үүнд гарч байгаа ойролцоо утгат үйл үгсийг түүвэрлэн авч анализ хийлээ. Энэхүү судалгааны ажилдаа түүвэр судалгааны арга, задлан шинжлэх болон нэгтгэн дүгнэх, тайлбарлах аргуудыг хэрэглэлээ.

Үүнд:

**Hire/Employ** - Хам сэдвээсээ шалтгаалж дараах хоёр үйл үгс нь өөр өөр утгатай байдаг. Гэхдээ Монгол хэлэнд “ажиллуулах, ажилд авах” гэсэн утгыг илэрхийлэхдээ ижил байдаг ч хэрэглээний хувьд бага зэрэг ялгаатай. ‘Hire’ гэдэг үг үгийг байнгын эсвэл түр зуурын ажилд авч ажиллуулах гэсэн утгаар хэрэглэдэг бол ‘employ’ нь байнгын ажилд авч ажиллуулах гэсэн утгыг илэрхийлдэг байна. Жишээлбэл: Let's **hire** someone to help with producing economic data tomorrow (<http://www.manythings.org/>). Уг өгүүлбэрийн утгаас харахад **hire** гэдэг үг нь түр зуурын ажилд авч ажиллуулах гэсэн утгыг илэрхийлж байна. We should **employ** more computer programmers and technical support staff at our company (<http://www.manythings.org/>). Энэ өгүүлбэрт **employ** гэдэг үг нь байнгын ажилд авч ажиллуулах гэсэн утгыг илэрхийлж байна.

**Evaluate/Calculate** - Энэхүү хоёр үг нь монгол хэлэнд орчуулагдах байдлын хувьд өөр өөр байдаг. ‘evaluate’ гэдэг үйл үг “үнэлэх” гэсэн утгатай бол ‘calculate’ нь “тооцоолох, тооцоолон бодох” гэсэн утгатай юм. Өөрөөр хэлбэл ‘evaluate’ нь хувьсагчийн тусламжтайгаар аливаа зүйлийн хийсвэр холбоо хамаарлыг илэрхийлэхэд хэрэглэгддэг байхад харин ‘calculate’ нь өгөгдсөн тоонд үндэслэн тодорхой тоон хариу гаргахад хэрэглэгдэнэ. Жишээлбэл: The plan you create will help to break down and **evaluate** all the economic factors that will have an impact on your business (<http://www.manythings.org/>). Энэ тохиолдолд ‘evaluate’ нь хийсвэр холбоо хамаарлыг илэрхийлж байна. She **calculated** that she had earned 1,500 dollars (<http://www.manythings.org/>). Харин энэ өгүүлбэрт ‘calculate’-ийн хувьд тодорхой тоон хариу гаргахад хэрэглэгдэж байна.

**Assess/Evaluate** - Харин ‘assess’ болон ‘evaluate’ гэдэг үгс нь Монгол хэлэнд орчуулагдахдаа “үнэлэх” гэсэн утга илэрхийлэх байдлаараа бие биеэ орлох чадвартай ойролцоо утгатай үгс гэж ойлгогддог боловч хам сэдвээс хамааран хэрэглээний хувьд харилцан адилгүй байна. Мөн тайлбар толь бичигт ‘assess’ гэдэг үг нь “одоогийн нөхцөл байдалдаа ахиц гаргах зорилгоор тоон мэдээллийг цуглуулан, тэдгээрийн тусламжтайгаар үнэлгээ хийх” гэсэн тайлбартай байгаа бол харин ‘evaluate’ нь “тодорхой нэг стандарт, дүрэм журамд үндэслэн шүүн тунгаах байдлаар үнэлгээ хийх” гэсэн утгатай байна. Жишээлбэл: She was trained to **assess**, protect, repair, and sustain government systems through any kind of crisis (<http://www.manythings.org/>). Энэ өгүүлбэрээс харахад ямар нэг төрлийн хямралаар дамжуулан үнэлэх гэсэн байна. Students are required to critically **evaluate** the company usage of ICT in the light of what they are learning in the module

(<https://www.researchgate.net/>). Харин энэ өгүүлбэрт хичээлийн жилийн модульд үзэж судалсан зүйлдээ үндэслэн үнэлгээ өгөх гэсэн утгыг илэрхийлж байна.

**Influence/Affect** - Энэхүү хоёр үг нь “нөлөөлөх” гэсэн утгаараа ижил, бие биеэ бүрэн орлох ойролцоо утгатай үгс мэт боловч зарим тохиолдолд биесээ бүрэн орлох чадамжгүй байна. Жишээлбэл: He seems to be **affected** by his loss (<https://www.quickanddirtytips.com/>). Уг өгүүлбэрт ‘affect’ гэсэн үйл үг нь ‘сөргөөр нөлөөлөх’ гэсэн утгыг илэрхийлж байна. His smoking was influenced by the other members of the economic department (<https://www.tobaccoinaustralia.org.au/>). Харин удаах өгүүлбэрт ‘influence’ нь “нөлөөлөх” гэсэн утгатай байгаа ч энэ тохиолдолд эерэг эсвэл сөрөг нөлөөллийн алиныг нь ч илэрхийлж болно. Үүнийг хам сэдвээс мэдэх боломжтой юм.

**Use/Utilize** - Эдгээр үйл үгс нь “хэрэглэх, ашиглах” гэдэг утгаараа ижил юм шиг хэдий боловч өгүүлбэрт хэрэглэгдэх байдлын хувьд ялгаатай байна. Жишээлбэл: You can **use** my computer for analysis on economic condition. Please **utilize** the sport hall for the economic forum this afternoon (<https://theconversation.com/>). Эхний өгүүлбэрт ‘use’ нь тухайн компьютерийг зориулалтын дагуу хэрэглэх гэсэн утгатай байгаа бол дараагийн өгүүлбэрт ‘utilize’ нь спорт заалыг зориулалтын бус байдлаар хэрэглэх гэсэн утгыг илэрхийлж байна.

**Predict/Anticipate** - ‘Predict’ болон ‘anticipate’ үйл үгс нь “урьдаас хэлэх, таамаглах” гэсэн утгаараа ижил мэт боловч хэрэглээний хувьд ялгаа харагдана. Жишээлбэл: We **anticipate** at least 500 economists will come to the forum, so we’d better make sure we have enough seat for everyone (<http://www.manythings.org/>). Энэ өгүүлбэрт ‘anticipate’ нь ойрын хугацаанд болох үйл явдалын талаар өөрт буй мэдээлэлд тулгуурлан урьдаас таамаглах гэсэн утгатай байна. MIT has **predicted** global economic collapse by 2030 (<http://www.manythings.org/>). Харин энэхүү өгүүлбэрт ‘predict’ нь холын ирээдүйд болох зүйлийг ямар нэг мэдээлэл баримтад үндэслэхгүйгээр урьдаас таамаглахыг илэрхийлж байна.

**Produce/Make** - Уг хоёр үйл үгс нь “хийх, үйлдвэрлэх” гэсэн утгаараа бие биенээ бүрэн орлох боломжтой боловч өгүүлбэрийн бусад гишүүдтэй хэрэглэгдэн утга илэрхийлэх байдал нь ялгаатай байна. Жишээлбэл: This chair was **produced** of wood. This chair was **made** of wood (<https://tatoeba.org/>). Эдгээр хоёр өгүүлбэрт утга нь ижил байгаа ч хэрэглээний хувьд of угтвар үгтэй тохирох нь make үйл үг юм.

**Substitute/Replace** - Эдгээр үйл үгс нь “орлуулах” гэх утгын хувьд бие биесээ орлох боломжтой ч угтвар үгтэй нийлж холбоо үг үүсгэх байдлын хувьд ялгаатай байна. Жишээлбэл: Indeed, it was not until Mr. Rowan got the Dutch government, about 1838, to **substitute** jute yarns **for** those made from flax in the manufacture of the coffee bagging for their East Indian possessions, that the jute trade in Dundee got a proper start. It may seem intuitive at first glance, this idea that somehow there are only so many jobs and if you **replace** people **with** machines, people have fewer jobs (<https://sentence.yourdictionary.com/>). Эхний өгүүлбэрт ‘substitute’ үйл үг нь ‘for’ гэсэн угтвар үгтэй хэрэглэгдэж байгаа бол харин дараагийн өгүүлбэрт ‘replace’ гэх үйл үг нь ‘with’ үйл үгтэй хэрэглэгдэж “ямар нэг зүйлийг өөр зүйлээр орлуулах” гэсэн утгыг илэрхийлж байна. (Roberts, 2012)

**Expand/Extend** - Эдгээр хоёр үйл үгсийг ойролцоо утгатай үгс гэж үздэг боловч Монгол хэлэнд орчуулагдах байдал нь өөр өөр байна. Жишээлбэл: [The Red Cross is extending aid to those affected by the disaster](http://www.manythings.org/) (<http://www.manythings.org/>). Энэ өгүүлбэрт ‘extend’ үйл үг нь тусламжийн хэмжээгээ нэмэгдүүлэх гэсэн утгатай байхад харин дараах өгүүлбэрт ‘expand’ үйл үг нь бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх гэсэн утгатай байна.

I don't think we should **expand** our business in the current economic climate (<http://www.manythings.org/>).

**Allocate/Distribute** - 'Allocate' болон 'distribute' үйл үгс нь “тараах, хуваарилах” гэсэн утгаараа ижилхэн ойлгогддог ч хэрэглээний хувьд илэрхийлэх утга нь өөр өөр байна. Жишээлбэл: It also helps to **distribute** the products of the city's factories and the National government has done much to sustain this commerce by deepening and lighting the channel. This section of the business plan shows the reader how the business will **allocate** resources (<http://www.manythings.org/>). Эхний өгүүлбэрт 'distribute' нь ямар нэг шийдэл гаргах шаардлагагүйгээр тарааж хуваарилах гэсэн утгатай байгаа бол хоёр дох өгүүлбэрт 'allocate' нь аилваа нэг шийдэлийн үндсэн дээр хуваарилах гэсэн утга илэрхийлж байгаа нь гол ялгаа нь юм.

**Buy/Purchase** - Эдгээр үгс нь “худалдан авах” гэсэн утгыг илэрхийлэх байдлаараа адил ч хэрэглээний хувьд тодорхой ялгаа байна. Жишээлбэл: Most people **buy** Apple TV, but a few **buy** the Roku XDS Streaming Player (<http://www.manythings.org/>). Энэ өгүүлбэрт 'buy' үйл үг нь бараа бүтээгдэхүүнийг жижиглэнгээр худалдан авах гэсэн утгыг илэрхийлж байгаа бол дараах өгүүлбэрт 'purchase' үйл үг нь бараа бүтээгдэхүүнийг бөөнөөр худалдан авах гэсэн утга гаргаж байна. The weight of this ideal gold dollar would be adjusted at intervals in accordance with its power to **purchase** commodities as shown by the "index number" of prices (<https://sentence.yourdictionary.com/>). Мөн нэг гол ялгаа нь гэвэл 'buy'-г өдөр тутмын яриандаа илүү хэрэглэдэг бол харин 'purchase' нь албан яриа болон бичигт илүү хэрэглэгддэг.

**Select/Choose** - Эдгээр үгс “сонгох, шилэх” гэсэн утгаар хэрэглэгдэх байдлаараа ялгаагүй мэт боловч зарим нэг ялгаа ажиглагдаж байдаг. Жишээлбэл: 'select' нь ямар нэг үнэлэлт дүгнэлт өгсний эцэст шилж сонгох гэсэн утгыг илэрхийлж байгаа бол 'choose' нь ямар нэг зүйлийг сонирхолын дагуу илүүд үзсэний эцэст сонгохыг илэрхийлж байна. Ballots are held to **select** which individual assembly members may present bills. Buying a house gives you the opportunity to **choose** a unique and distinct architectural style and to personalize it (<https://ballotpedia.org/>). Мөн 'select' нь илүү албан утгаар хэрэглэгддэг.

**Acquire/Obtain** - Энэхүү 2 үгс нь “эзэмших, байлгах” гэсэн утгаараа ижил байхаас гадна хоёулаа илүү албан хэлэнд хэрэглэгддэг байна. Жишээлбэл: His goal was to **acquire** weapons of mass destruction and the means to deliver them (<http://unrcpd.org/>). Энэ өгүүлбэрт 'acquire' үйл үгийн оронд 'obtain'-ийг хэрэглэх боломжтой юм.

**Save/Store** - Эдгээр үгс нь ижил ойлгогддог боловч Монгол орчуулгын хувьд ялгаатай байдаг. Жишээлбэл: I need to **save** money for the poor and the unemployed (<http://www.manythings.org/>). Энэ өгүүлбэрт 'save' нь “хадгалах” гэсэн утгаар хэрэглэгдэж байгаа бол дараах өгүүлбэрт 'store' үйл үг нь “нөөцлөх” гэсэн утгаар хэрэглэгдэж байна. Nations need to **store** crops during economic depression (<http://www.manythings.org/>).

## 2. ҮР ДҮН

Судалгаанд хэрэглэгдэхүүн болгон түүвэрлэн авсан ойролцоо утгат үйл үгсийг судалж үзэхэд дараах үр дүнд хүрлээ. Үүнд:

➤ Монгол хэлэнд орчуулагдах байдал нь яг ижил боловч хам сэдвээсээ шалтгаалан утгын хэрэглээ өөр үгс

- Монгол хэлэнд орчуулагдах утга нь өөр, энэ байдлаараа утгын хэрэглээ нь ялгаатай үгс
- Монгол хэлэнд орчуулагдах утга нь яг адил боловч холбоо үгийг бүрдүүлж байгаа элементээсээ шалтгаалан бүтцийн хэрэглээ өөрчлөгддөг үгс
- Монгол хэлний орчуулга ижил байв ч албаны хэллэгт хэрэглэгдэх байдал нь эсрэгцдэг үгс.
- Монгол хэлний орчуулга болон албаны хэллэгт хэрэглэгдэх байдал нь адил үгс.

## ДҮГНЭЛТ

Эрдэмтдийн тодорхойлсны дагуу синоним гэдэг нь яг адилгүй боловч ойролцоо утга илэрхийлэх хэлний арга хэрэглүүр бөгөөд нэг талаас эдгээр үйл үгс нь бие биенээ бүрэн орлох боломжгүй гэсэн утгатай дүйж байгаа ч нөгөө талаас хэрэглээний явцад хам сэдвээс шалтгаалж энэхүү үйл үгс нь бие биенээ бүрэн орлох боломжтой гэсэнтэй санал нэг байна. Тиймээс эдгээр ойролцоо утгат үйл үгс нь хэрэглээ болон орчуулагдах байдлаасаа шалтгаалан нэгийг нөгөөгөөр нь сольж хэрэглэхэд зарим тохиолдолд болох боловч ихэнхдээ найруулгын талаар (хам сэдэв), мөн хэрэглэж хэвшсэн байдлын хувьд ялгаатай тул сольж хэрэглэж болохгүй гэсэн дүгнэлтэд хүрэв.

## АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. Бямбасан, П. (1982). Орчин цагийн монгол хэлний синоним. Монгол хэлний онол, бүтцийн асуудалд, 11(2), 45-46
2. Базаррагчаа, М. (2005). Монгол хэлний өгүүлбэр судлал. Улаанбаатар: Соёмбо
3. Отгонсүрэн, Д. (1998). Ойролцоо утгат үгийн найруулгын үүрэг. Монгол хэлний үгийн сангийн найруулга зүй, 14(3), 31-32
4. Translation theory. (2015). Cit.01/12/2020.  
Retrieved from translation theory, <http://theoryoftranslations.blogspot.com/>
5. Roberts, M. (2012). English for Economics in higher education (1<sup>st</sup> ed.). UK: Garnet publishing